

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР  
ТУТМЫН ТОЙМ**

2015.03

**Үзүүлэлтүүд:**

<b>ДНБ 7.8%</b>	<b>ГШХО 3-р сард 9.7 сая ам.доллар</b>	<b>Төсвийн тэнцэл (144.6) тэр бум төгрөг</b>	<b>Инфляци 9.3%</b>	<b>Чанаргүй зээл 36 тэрбум төгрөгөөр өслөө</b>	<b>Валютын нөөц 1362.5 сая ам.доллар</b>
Өсөлтөнд ХАА салбар 14.4%, аж үйлдвэр, барилгын салбар 16.1%, үйлчилгээний салбар 4.8%-иар өссөн нь нөлөөлжээ.	Цэвэр ГШХО өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142.1 сая ам.доллараар буурч, өмнөх сараас 97.9 сая ам.доллараар өсч 9.7 сая ам.доллар.	Төсвийн орлого 1.2 их наяд төгрөг, зарлага 1.37 их наяд төгрөг, тэнцэл 144.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 36 тэрбум төгрөг буюу 5.4%-иар өсөж <b>703 тэрбум төгрөгт</b> хүрэв.	Монгол банкны валютын нөөц өмнөх сараас 2.6 хувь буюу 34.7 сая ам.доллараар өсч 1362.5 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш  
**1986 төгрөг**



Орон сууцны үнийн индекс  
**1,173**  
Өмнөх сараас 0.05%-иар өсч, өмнөх жилээс 6.7%-иар буурлаа.



Монголбанкны бодлогын хүү  
1%-иар нэмэгдэж  
**13%**




Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр.  
1975 оноос хойш 3 сарын 8-ны өдрийг жил болгон олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдөр болгон дэлхийн өнцөг булан бүрт тэмдэглэсээр ирсэн байна.

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.

*Эх сурвалж:*

ҮСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

*Эх сурвалж: ҮСХороо*

**Ажлын айлчлал**

хийв



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2015 оны гуравдугаар сарын 2-4-нд ХБНГУ-д ажлын айлчлал хийв. Тэрбээр айлчлалынхаа хүрээнд ХБНГУ-ын Ерөнхийлөгч И.Гаук, Канцлер А.Меркельтэй тус тус уулзаж, Берлин хотноо зохиогдсон Монгол, Германы бизнесийн форумд оролцов.


**ДНБ**

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (2014 оны урьдчилсан гүйцэтгэл) 15.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 7.8 хувиар өслөө. Үүнд: ХАА-н салбар 14.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 16.1 хувь, үйлчилгээний салбар 4.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ гуравдугаар сард 1.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 1.4 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 144.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 14.5 тэрбум төгрөгөөр буурсан. Алдагдлын бууралтанд татварын өсөлт 10 хувиар өссөн нь нөлөөлжээ.



**Валютын хани**

Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш ханш 1986.22 болж, өнгөрсөн оны мөн үеэс 210 төгрөг буюу 12.1 хувь, өмнөх сараас 24.5 төгрөгөөр буюу 1.2 хувиар тус тус суларсан байна. (Улмаар импортын хэмжээ буурч, экспортын хэмжээ нэмэгдэж байна. Энэ нь нэг талаараа эдийн засагт эерэг үр дүнг авчирч байна.)



**Инфляци**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны гуравдугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, хувцас, бөс, бараа, гутлын бүлгийнх 0.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны хоёрдугаар сарын байдлаар 1362.5 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 2.6 хувь буюу 34.7 сая ам.доллараар өссөн, өнгөрсөн оны мөн үеэс 37.9 хувь буюу 833 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Монголбанкинд алт тушаалтын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 41 хувиар буурч 985.5 кг болсон байна.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**

Үнэт цаасны арилжаагаар 2015 оны эхний улиралд 162.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 14.1 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 143.4 тэрбум төг буюу 8.4 дахин, арилжигдсан үнэт цаас 10.7 сая ш буюу 4.1 дахин өссөн байна. ТОП-20 дундаж индекс 2015 оны 3 дугаар сард 13516.2 болж, өмнөх сарынхаас 487.3 нэгжээр буурчээ. Хөрөнгийн бирж үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 3 дугаар сард 1.3 их наяд төг болж, өмнөх сарынхаас 54.4 тэрбум



\* Монголын хөрөнгийн бирж


**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны эхний улирлын байдлаар 9.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 327 тэрбум төгрөг буюу 3%-иар, өмнөх оны мөн үеэс 35 тэрбум төгрөг буюу 0.4%-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө эхний улирлын байдлаар 702.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 73.1 тэрбум төгрөг буюу 9%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 98.3 тэрбум төгрөг буюу 12%-иар тус тус буурсан байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2015 оны эхний улирлын байдлаар өнгөрсөн сараас 145 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар буурч 7370.2 тэрбум төгрөг болов. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 187.6 тэрбум төгрөг буюу 2.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж буурахад төгрөгийн хадгаламж 3.3 хувиар буюу 178.8 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ. Нийт хадгаламжийн 29.6 хувийг валютын хадгаламж эзэлж өнгөрсөн жилээс 1.8 пунктаар өссөн байна.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны эхний улирлын байдлаар 12.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 94 тэрбум төгрөг буюу 0.8%-иар, өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөг буюу 7.8%-иар тус тус өслөө. Харин чанаргүй зээлийн хэмжээ 703 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 5.4% (36 тэрбум төгрөг), өнгөрсөн оны мөн үеэс 18.3% (108 тэрбум төгрөг) өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 6 сар дараалан өсөөд байна.



**Ипотекийн зээл**

2015 оны хоёрдугаар сарын байдлаар нийт ипотекийн зээл өмнөх сараас 1.7 хувь (50.5 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 39 хувь (827.5 тэрбум төгрөг) -иар нэмэгдэж 2.94 их наяд төгрөгт хүрэв. Хоёрдугаар сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.1 хувь нь төгрөгийн, 1.9 хувь нь гадаад валютын зээл байна. Нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувийг Улаанбаатар хотод, 23 хувийг хөдөө орон нутагт олгосон




\* Эх сурвалж Монголбанк

Хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.7 хувь буюу 102.5 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.9 хувь буюу 98.2 тэрбум төгрөг Орхон аймагт, 9 хувь буюу 59.6 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.

**Гадаад худалдаа**

**Гадаад худалдаа**


2015 оны эхний улирлын худалдааны нийт бараа эргэлт 1779.5 сая ам.доллар, үүнээс экспорт 1077.7 сая ам.доллар, импорт 701.7 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 376 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 203.4 сая ам.доллар буюу 10 хувь, үүний дотор импортын хэмжээ 294.3 сая ам.доллар буюу 30 хувиар буурсан бол экспортын хэмжээ 90.8 сая ам.доллар буюу 9 хувиар өсчээ. Экспорт нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, машин тоног төхөөрөмж, хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспорт нөлөөлсөн бол импортын бууралтад машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг гэх мэт бүтээгдэхүүний импорт буурсан нь голлон нөлөөлөв.



\* Эх сурвалж ҮСХ, МБ

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр тайлант сард 9.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэнээр 2015 оны эхний хоёр сарын байдлаар сөрөг дүнтэй буюу (78.5) сая ам.долларын үзүүлэлттэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 142.1 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Үүнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн толгой компаниас авсан зээлийн эргэн төлөлт их хэмжээгээр хийгдсэн тул 2015 оны хоёрдугаар сарын эцэст гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал сөрөг дүнтэй гарсан нь нөлөөлжээ.



\* Эх сурвалж МонголБанк

## Монгол Улсын гадаад өр, зээлжих зэрэглэл


### Гадаад өр

#### Засгийн газрын нийт гадаад өр 3.6 тэрбум ам.доллар байна.

2014 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 20.9 тэрбум доллар байсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 10 хувь (1.9 тэрбум ам.доллар) өссөн бол өмнөх улирлаас 0.04 хувь (8.2 сая ам.доллар) буурсан байна.

Нийт өрийн 17 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төвбанкны өр, 8 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 17 хувийг бусад салбаруудын өр, 51 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

Төвбанкны нийт өрийн 95 хувийг богино хугацаат, 5 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



\* Эх сурвалж Монголбанк

### Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3 911,50	4 089,20	4 299,10	4 169,30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2 760,80	2 625,00	2 550,00	2 490,00
Засгийн газрын баталгаа	2 305,50	2 515,80	2 439,20	1 312,50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8 977,80	9 230,00	9 288,30	7 971,80

\* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

## Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих  
зэрэглэл

Монгол Улс	S&P		Fitch	
	B+	Тогтвортой	B+	Сөрөг
Огноо	2014.04.29		2013.12.13	

Standard & Poor's 2014 оны 4-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулж урт хугацаанд “BB-” байсныг “B+” болгон бууруулж, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “B” болгон тогтоосон. Үүнээс өмнө манай улсын зээлжих зэрэглэл “BB+” гэсэн ангилалд багтаж байсан билээ. S&P : МУ-ын зээлжих зэрэглэлд 2014 оны дөрөвдүгээр сараас хойш өөрчлөлт гараагүй байна. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт 50 орчим хувиар буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

**Moody's :**

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг юм.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

**Moody's өнгөрөгч оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.**

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B 2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

Уг шийдвэртэй холбоотойгоор тус агентлагийн зүгээс Монголын Засгийн газрын эзэмшлийн Хөгжлийн банкны зэрэглэлийн ирээдүйн төлөвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан ба Хөгжлийн банкны хоёрдогч өглөгийг B1, хоёрдогч дунд хугацаат өрийн бичгийг B1 гэж үнэлсэн юм. 2015 оны гуравдугаар сард Moody's МУ-ын арилжааны банкуудын зээлжих зэрэглэлийн тайланг гаргажээ. Энэхүү тайланг сайтаас нь татах боломжтой.

\* Эх сурвалж <http://www.moody.com/>  
<http://www.standardandpoors.com/>  
<http://www.fitchratings.com/>

**Сарын онцлох үйл явдал**

- 03.02-03.04-нд** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2015 оны гуравдугаар сарын 2-4-нд ХБНГУ-д ажлын айлчлал хийв. Тэрбээр айлчлалынхаа хүрээнд ХБНГУ-ын Ерөнхийлөгч И.Гаук, Канцлер А.Меркельтэй тус тус уулзаж, Берлин хотноо зохиогдсон Монгол, Германы бизнесийн форумд оролцсон байна.
- 03.04-нд** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2015 оны гуравдугаар сарын 4-8-нд ХБНГУ-ын Берлин хотноо болох олон улсын аялал, жуулчлалын “ITB Berlin 2015” үзэсгэлэнгийн нээлтийн ёслолын арга хэмжээнд түнш орны төрийн тэргүүний хувиар уригдан оролцож, үг хэлжээ.
- 03.14-03.21 -нд** Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд ХБНГУ-ын Бундестагийн Ерөнхийлөгч Н.Ламмерттын урилгаар 2015 оны гуравдугаар сарын 14-18-ны өдрүүдэд ХБНГУ-д, БНПУ-ын Сенатын Маршал Богдан Борусевичийн урилгаар гуравдугаар сарын 18-21-ний өдрүүдэд БНПУ-д тус тус албан ёсны айлчлал хийлээ.
- 03.17-нд** **Зүүн хойд Азийн орнууд эрчим хүчний асуудлаар хуралдав.** “Эрчим хүчний хэлхээ холбоо” сэдэвт Зүүн хойд Азийн орнуудын шинжээчдийн түвшний уулзалт гуравдугаар сарын 17-ны 09:00 цагт Гадаад хэргийн яаманд боллоо. Хуралд Монголын төр, хувийн хэвшил, ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ, Япон зэрэг Зүүн хойд Азийн орнуудын Эрчим хүчний судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдийн төлөөлөл, олон улсын болон хувийн хэвшлийн 16 байгууллагын 24 эрдэмтэн судлаачид оролцсон байна
- 03.22** Монголын хүн амын дөрвөн хувь болох казахуудын үндэстний баяр Наурызын баяр гуравдугаар сарын 22-нд боллоо. Нарны баяр буюу Наурыз нь Цагаан сартай төстэй боловч Монгол тооллолыг сарны тооллоор хөтөлдөг бол Наурыз шинэ жилийг нарны тооллоор хөтөлдөг юм байна. Энэ өдөр, шөнө тэнцдэг тул ийнхүү шинэ жил, шинэ өдөр гэж тэмдэглэдэг ажээ.

**Тойм**

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдлаа.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл)-ийн хуралдаан 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хуралдлаа. Хуралдаанаар: Иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцааны бүртгэлийн тухай, Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны үйл ажиллагааны тухай, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх төлөвлөгөө, Дэлхийн банкны хөгжлийн бодлогын зээлийг авах нөхцөл, авах арга хэмжээ, Хөгжлийн банкны зарцуулалт, засаглалыг боловсронгуй болгох тухай, Төрийн өмчийн активын удирдлагын нэгж байгуулах тухай, Гадаад валютын дотоод захын тойм, Инфляцийн төлөв байдлын тайлан зэрэг багц асуудлуудыг хэлэлцэв.

Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн байна.

Энэ оны гуравдугаар сарын 12-нд Засгийн газрын ээлжит бус хуралдаан болж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ. Үүнд: Эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт олборлох үйлдвэрлэлийг дэмжиж, олборлолтод бэлтгэгдсэн алтны ордны хөрөнгө оруулалтыг судалж, санхүүжүүлэх талаар арга хэмжээ авах, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт тус тус даалгаж, зохих журмын дагуу хянаж, санхүүжүүлэхийг Хөгжлийн Банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбатад зөвшөөрөн, санхүүжилтийн оновчтой схемийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монголбанкны ерөнхийлөгч Б.Золжаргалд зөвлөлөө.